

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

<b>1</b>	<b>Аудитын гэрчилгээ</b> .....	Error! Bookmark not defined.
<b>2</b>	<b>Аудитын тайлан</b> .....	<b>4</b>
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
<b>3</b>	<b>Менежментийн захидал</b> .....	<b>9</b>
3.1	Балансын данстай холбоотой .....	9
3.2	Балансын данстай холбоотой .....	9
3.3	Үйл ажиллагаатай холбоотой.....	10
<b>4</b>	<b>Аудит хийсэн санхүүгийн тайлан</b> .....	<b>11</b>
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
<b>5</b>	<b>Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт</b> .....	<b>19</b>

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН  
ГАЗРЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ЭРДЭНЭ-ОЧИР ТАНАА

2019.02.25 № 06/312  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тээврийн прокурорын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Тээврийн прокурорын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Тээврийн прокурорын газар 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. АУДИТЫН ТАЙЛАН**

### **Оршил**

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Тамгын газрын дарга Б.Эрдэнэ-Очир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 26-наас 2019 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Пантер мидланд аудит” ХХК-ийн аудитор А.Долгор хэрэгжүүлэв.

Тээврийн прокурорын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Пантер мидланд аудит” ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/192 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн боловч Ерөнхий прокурорын газартай тооцоо нийлж төсвийн гүйцэтгэлийн тайланд засвар хийгдсэн ба засвар хийгдсэн санхүүгийн тайлангаа 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдөр анхан шатны баримтуудын хамт ирүүлсэн байна.

## **Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Тээврийн прокурорын газар нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх арга хэмжээ авах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Прокурорын тухай хуулиар Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Прокурор зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих
- Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах бүртгэх, бүртгэх үйл ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх
- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх
- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны явцад хуулийг зөв хэрэглэж байгаа эсэх
- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангаж байгаа эсэх

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Прокурорын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

#### **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Энгийн буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

#### **Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

#### **МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардалыг сонгов.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа тээврийн прокурорын газрын 2018 оны нийт зардал 750,959.5 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 15,019.19 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

#### **Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд материаллаг бус зөрчилтэй 3 асуудал илэрсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан асуудал гараагүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг хүснэгтэд тусгав

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

				/мянган төгрөг/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	619.8	Мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй
Дүн		3	619.8	

#### **2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад менежментийн захидалд оруулах зөвлөмжөөс гадна бусад хэлбэрээр шийдсэн алдаа зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### **ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

- Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2018 оны 12 дугаар сарын 26 өдрийн Б/464 тоот тушаалын дагуу Тээврийн прокурорын газраас 21400.0 мянган төгрөгийг Ахмадын холбооны газарт төвлөрүүлэх шийдвэр гарсан байна. Уг тушаалд Тээврийн прокурорын газрын төвлөрүүлэх хөрөнгийн хязгаарыг зааж өгөөгүй байна.

- Өмнөх аудитаар дараагийн аудитаар анхаарах асуудлыг авч үзэхээр тусгасан боловч 2018 онд энэ асуудлын талаар анхаарч үзээгүй байна. Тээврийн прокурорын газрын нягтлан бодогч давхар ажил эрхэлж байгаа нь нягтлан бодох бүртгэлийн ажлыг

тууштай хариуцлагатай хийх, дотоод хяналт хэрэгжүүлэх, мөн санхүүгийн тайлан, анхан шатны баримт, шаардлагатай материалыг хуулийн хугацаанд аудитын байгууллагад өгөх хугацааг хоцроосон нь АОУС 210 “Аудитын ажлын нөхцөлийн тохирох” гэсэн стандарттай нийцэхгүй байгааг дахин авч үзэх шаардлагатай байна.

#### **ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 726,509.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 726,379.2 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна

#### **Шилэн дансны мэдээлэл**

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг шалгахад худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үндсэн үйл ажиллагааны орлого, төсөв байгууллагын өөрийн орлого, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, хөрөнгийн зардал, татаас шилжүүлэг, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг дутуу мэдээлсэн байна. Бусад үзүүлэлтүүдийг бүрэн мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

#### **ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулалтыг АДБОУС-ындагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа тээврийн прокурорын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа тээврийн прокурорын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ**

##### **3.1.1. Илрүүлэлт:**

Санхүүгийн тайлангаар төрийн өмч дансны үлдэгдэл 110,905.9 төгрөг болсон байна. Улс бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт хийлгээгүй байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Мэдээлэл хэрэглэгчдийн шийдвэрт сөрөг нөлөө үзүүлэх

##### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

Төрийн өмчийн дансны дүнг Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлэх

##### **3.1.4. Байгууллагын өгсөн хариу, тайлбар**

Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулна.

#### **3.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ**

##### **3.2.1. Илрүүлэлт:**

2018 оны 4 дүгээр улиралд 619.8 мянган төгрөгийн томилолтын зардал гарсан байна. Томилолтоор ажилласан ажилтан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан журмын дагуу мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй байна.

##### **3.2.2. Эрсдэл:**

Өр авлага нэмэгдэх, зардал буруу тооцогдох

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар баталсан маягтаар мөнгөн урьдчилгааны тайланг гаргуулж, тооцоо бодож байх

3.2.4. Байгууллагын өгсөн хариу, тайлбар:

Мөнгөн урьдчилгааны маягтаар тайлан гаргуулж, тооцоо хийж байна.

**3.3 Үйл ажиллагаатай холбоотой**

3.3.1. Илрүүлэлт:

2018 оны шилэн дансны мэдээллийг шалгахад дараах мэдээллүүд дутуу байна. Үүнд: Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /бүтэн жилээр/, тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, татаас шилжүүлэг

3.3.2. Эрсдэл:

Хяналтыг сулруулах, мэдээлэл хэрэглэгчдийн шийдвэрт сөрөг нөлөө үзүүлэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх

3.3.4 Байгууллагын өгсөн хариу, тайлбар:

Анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2019 оны 09 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,599,983.59</b>	<b>14,059,242.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	487,643.59	1,503,884.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	487,643.59	1,503,884.00
3351	Байгууллагаас авах авлага	131,449.59	268,628.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	356,194.00	1,235,256.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8,112,340.00	12,555,358.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	55,500.00
35110	Тусгай зориулалттай материал		55,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,112,340.00	12,499,858.00
35410	Бичиг хэргийн материал	165,500.00	1,283,600.00
35420	Аж ахуйн материал	7,743,580.00	7,743,580.00
35440	Түлш, шатах тослох материал		299,183.00
35470	Бусад хангамжийн материал	203,260.00	3,173,495.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>50,739,754.78</b>	<b>43,750,415.35</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	50,739,754.78	43,750,415.35
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	50,739,754.78	43,750,415.35
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,900,000.00	69,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-52,011,111.04	-55,844,444.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,097,813.75	45,328,722.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,740,845.76	-39,551,737.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,942,492.70	47,867,492.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,448,594.87	-23,949,617.63
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>59,339,738.37</b>	<b>57,809,657.35</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>41,988.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	41,988.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	41,988.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	41,988.00
41361	Байгууллагад төлөх өглөг		41,988.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>59,339,738.37</b>	<b>57,767,669.35</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	59,339,738.37	57,767,669.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	110,905,897.88	110,905,897.88
51101	Өмч: - төрийн	110,905,897.88	110,905,897.88
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-51,566,159.51	-53,138,228.53
51210	Өмнөх үеийн үр дүн	-51,566,159.51	-51,566,159.51
51220	Тайлант үеийн үр дүн		-1,572,069.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>59,339,738.37</b>	<b>57,809,657.35</b>

#### 4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>702,434,085.25</b>	<b>749,387,422.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,707,285.25</b>	<b>7,878,222.88</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,707,285.25</b>	<b>7,878,222.88</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,707,285.25	5,826,291.33
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,707,285.25	5,826,291.33
120009	Бусад орлого		2,051,931.55
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>700,726,800.00</b>	<b>741,509,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>700,726,800.00</b>	<b>726,509,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	700,726,800.00	726,509,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>15,000,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		15,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>721,344,578.78</b>	<b>750,959,491.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>721,344,578.78</b>	<b>750,959,491.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>721,144,578.78</b>	<b>750,109,502.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>595,258,649.34</b>	<b>602,964,240.92</b>
210101	Үндсэн цалин	554,884,649.34	585,987,340.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,374,000.00	16,976,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,172,000.00</b>	<b>72,384,471.36</b>
210201	Тэтгэврийн даатгал	67,172,000.00	72,384,471.36
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,677,480.00</b>	<b>19,590,965.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,266,409.00	1,405,600.00
210302	Түлш, халаалт	8,327,096.00	9,313,005.00
210303	Цэвэр, бохир ус	431,300.00	1,045,800.00
210304	Байрны түрээс	4,652,675.00	7,826,560.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,941,978.00</b>	<b>19,539,424.04</b>
210401	Бичиг хэрэг	9,246,445.49	4,013,150.00
210402	Тээвэр, шатахуун	5,249,016.00	7,046,654.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,356,216.51	1,424,559.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		689,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,090,300.00	6,365,261.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>29,950.00</b>	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,950.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>575,000.00</b>	<b>8,499,500.00</b>
210604	Урсгал засвар	575,000.00	8,499,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>101,000.00</b>	<b>1,573,210.00</b>
210702	Дотоод албан томилолт	101,000.00	1,573,210.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,000,000.00</b>	<b>2,936,243.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,750,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	988,443.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		197,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,388,521.40</b>	<b>22,621,447.76</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	475,618.00	9,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	700,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,512,903.40	12,021,447.76

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа тээврийн прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>200,000.00</b>	<b>849,989.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	200,000.00	720,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	720,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>129,989.82</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		129,989.82
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-18,910,493.53</b>	<b>-1,572,069.02</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-18,910,493.53</b>	<b>-1,572,069.02</b>

### 4.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр

Дан сны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>700,825,694.00</b>	<b>753,710,603.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>98,894.00</b>	<b>12,201,403.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>98,894.00</b>	<b>12,201,403.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,894.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	98,894.00	
120009	Бусад орлого		12,201,403.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>700,726,800.00</b>	<b>741,509,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>700,726,800.00</b>	<b>726,509,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	700,726,800.00	726,509,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>15,000,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		15,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>700,825,694.00</b>	<b>753,710,603.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>700,825,694.00</b>	<b>753,710,603.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>697,821,244.41</b>	<b>746,967,613.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>593,598,694.00</b>	<b>607,733,496.14</b>
210101	Үндсэн цалин	558,545,409.40	590,756,596.14
210102	Нэмэгдэл	17,944,947.60	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,108,337.00	16,976,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,172,550.41</b>	<b>72,619,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	67,172,550.41	48,590,100.00
210202	Тэтгэмжийн даатгал		6,007,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,805,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1,201,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал		12,014,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,647,885.00</b>	<b>19,613,965.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,332,955.00	1,405,600.00
210302	Түлш, халаалт	7,165,930.00	9,313,005.00
210303	Цэвэр, бохир ус	431,300.00	1,068,800.00
210304	Байрны түрээс	5,717,700.00	7,826,560.00

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа тээврийн прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,901,115.00</b>	<b>15,827,499.04</b>
2104 01	Бичиг хэрэг	7,796,200.00	6,080,750.00
2104 02	Тээвэр, шатахуун	4,535,000.00	5,218,782.00
2104 03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,051.51	1,577,571.04
2104 04	Ном, хэвлэл		545,000.00
2104 05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		929,410.00
2104 06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,769,863.49	1,475,986.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>9,583,900.00</b>
2106 04	Урсгал засвар	500,000.00	9,583,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>101,000.00</b>	<b>1,573,210.00</b>
2107 02	Дотоод албан томилолт	101,000.00	1,573,210.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,000,000.00</b>	<b>4,116,243.00</b>
2108 01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,930,600.00
2108 02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	988,443.00
2108 03	Даатгалын үйлчилгээ		
2108 04	Тээврийн хэрэгслийн татвар		197,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,900,000.00</b>	<b>15,900,000.00</b>
2109 01	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	15,000,000.00
2109 02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	900,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,004,449.59</b>	<b>6,742,989.82</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		<b>5,893,000.00</b>
2131 01	Засгийн газрын дотоод шилжүүлэг		5,893,000.00
2131 02	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,004,449.59</b>	<b>720,000.00</b>
2132 09	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,004,449.59	720,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>129,989.82</b>
2133 03	Төвлөрүүлэх шилжүүлэг		129,989.82
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

#### 4.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгэ эний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>110,905,897.88</b>		<b>-32,769,727.98</b>		<b>78,136,169.90</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			114,062.00		114,062.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>110,905,897.88</b>	<b>0.00</b>	<b>-32,655,665.98</b>	<b>0.00</b>	<b>78,250,231.90</b>
Тайлант үеийн үр дүн			-18,910,493.53		18,910,493.53
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>110,905,897.88</b>	<b>0.00</b>	<b>-51,566,159.51</b>	<b>0.00</b>	<b>59,339,738.37</b>
<b>2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>110,905,897.88</b>	<b>0.00</b>	<b>-51,566,159.51</b>	<b>0.00</b>	<b>59,339,738.37</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>110,905,897.88</b>	<b>0.00</b>	<b>-51,566,159.51</b>	<b>0.00</b>	<b>59,339,738.37</b>
Тайлант үеийн үр дүн			-1,572,069.02		-1,572,069.02
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>110,905,897.88</b>	<b>0.00</b>	<b>-53,138,228.53</b>	<b>0.00</b>	<b>57,767,669.35</b>

#### 4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>726,509,200.00</b>	<b>726,379,210.18</b>	-129,989.82	100.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>726,509,200.00</b>	<b>726,379,210.18</b>	-129,989.82	100.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>725,789,200.00</b>	<b>725,659,210.18</b>	129,989.82	100.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>601,486,000.00</b>	<b>601,425,093.14</b>	-60,906.86	100.00
210101	Үндсэн цалин	459,464,100.00	584,448,193.14	124,984,093.14	127.20
210102	Нэмэгдэл	125,045,000.00		125,045,000.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,976,900.00	16,976,900.00		100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,619,300.00</b>	<b>72,619,300.00</b>		100.00
210201	Тэтгэврийн даатгал	48,590,100.00	48,590,100.00		100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,007,300.00	6,007,300.00		100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,805,800.00	4,805,800.00		100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,201,500.00	1,201,500.00		100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,014,600.00	12,014,600.00		100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,681,600.00</b>	<b>19,613,965.00</b>	-67,635.00	99.70
210301	Гэрэл, цахилгаан	1,485,800.00	1,405,600.00	-80,200.00	94.60
210302	Түлш, халаалт	9,280,300.00	9,313,005.00	32,705.00	100.35
210303	Цэвэр, бохир ус	1,088,000.00	1,068,800.00	-19,200.00	98.24
210304	Байрны түрээс	7,827,500.00	7,826,560.00	-940.00	99.99
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,827,500.00</b>	<b>15,827,499.04</b>	-0.96	100.00
210401	Бичиг хэрэг	6,117,800.00	6,080,750.00	-37,050.00	99.39
210402	Тээвэр, шатахуун	5,218,800.00	5,218,782.00	-18.00	100.00

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа тээврийн прокурорын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,657,600.00	1,577,571.04	-80,028.96	95.17
210404	Ном, хэвлэл	545,000.00	545,000.00		100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	929,900.00	929,410.00	-490.00	99.95
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,358,400.00	1,475,986.00	117,586.00	108.66
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,584,000.00</b>	<b>9,583,900.00</b>	-100.00	100.00
210604	Урсгал засвар	9,584,000.00	9,583,900.00	-100.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,573,600.00</b>	<b>1,573,210.00</b>	-390.00	99.98
210702	Дотоод албан томилолт	1,573,600.00	1,573,210.00	-390.00	99.98
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,117,200.00</b>	<b>4,116,243.00</b>	-957.00	99.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,931,500.00	2,930,600.00	-900.00	99.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	988,500.00	988,443.00	-57.00	99.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,200.00	197,200.00		100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>900,000.00</b>	<b>900,000.00</b>		100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	900,000.00		100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>720,000.00</b>	<b>720,000.00</b>		100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>720,000.00</b>	<b>720,000.00</b>		100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	720,000.00	720,000.00		100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>726,509,200.00</b>	<b>726,379,210.18</b>	-129,989.82	99.98
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>726,509,200.00</b>	<b>726,379,210.18</b>	-129,989.82	99.98
131001	Улсын төсвөөс санхүүжих	726,509,200.00	726,379,210.18	-129,989.82	99.98
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	28	28		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14		
620003	Үйлчлэх ажилтан	13	13		

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>Тээврийн прокурорын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2019.02.			САГ-2019/184/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Тээврийн прокурорын газар</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Санхүүгийн тайлангаар төрийн өмч дансны үлдэгдэл 110,905.9 төгрөг болсон байна. Улс бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт хийлгээгүй байна.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Насанжаргал
2	2018 оны 4 дүгээр улиралд 619.8 мянган төгрөгийн томилолтын зардал гарсан байна. Томилолтоор ажилласан ажилтан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан журмын дагуу мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй байна.	619.8	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Насанжаргал
3	. 2018 оны шилэн дансны мэдээллийг шалгахад дараах мэдээллүүд дутуу байна. Үүнд: Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /бүтэн жилээр/, тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, татаас шилжүүлэг		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Насанжаргал
	<b>Дүн</b>	619.8			